



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/237

Ховд

Байршил тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "А" заалт, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлийн иргэдэд тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Ховд аймгийн Дарви сумын Мөрөн багийн нутаг дэвсгэрт орших тэсэлгээний бодисын үйлдвэрийн болон тэсрэх материалын агуулахын байршлын солбилцолыг 1 дүгээр, дэвсгэр зургийг 2 дугаар хавсралтаар тус тус тогтоосугай.

2.Уг байршлыг тогтоосонтой холбогдуулан Геологи, Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, мэдээллийн нэгдсэн санд хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Гантөмөр/-д үүрэг болгосугай.

3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлийг үйлдвэрийн болон хадгалах байр, агуулахад тогтоосон аюулгүй бүсийн хил хязгаарт иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшил болон өмчлөлөөр олгохгүй байхыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/, Дарви сумын Засаг дарга /О.Ганцоож/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2019 оны
04 дүгээр сарын 19-ний өдрийн
А/237 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

ТЭСРЭХ БОДИСЫН АГУУЛАХЫН ЭРГЭЛТИЙН
ЦЭГҮҮДИЙН СОЛБИЛЦОЛ

№	Систем UTM	
	X	Y
1	5181008.848	521792.977
2	5181113.351	521685.320
3	5181208.455	521777.644
4	5181105.042	521886.351


-oOo-

**ПАУЭР БЛАСТ ХХК (5455979) - ИЙН
ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ**

Огноо: --

Хаяг: Ховд аймаг Дарви сум Хөшөөт баг

Хашаа Талбайн хэмжээ: 19999.9 квадрат метр



Дугаар	X	Y	Ёндөр	Урт	Цэггйд
1	5181008.836	521792.985	0.000	150.02	1-2
2	5181113.316	521685.332	0.000	132.56	2-3
3	5181208.456	521777.641	0.000	150.04	3-4
4	5181105.039	521886.347	0.000	134.06	4-1

Зургийн масштаб 1:2000 (1 сантиметрт 20 метр багтана)

Зураг тйлдсэн: "БОСОО ТЭНХЛЭГ ВГБХНДГ" Л.ГАНЗОРИГ

